



“АКСИС КАПИТАЛ ББСБ” ХХК
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;
Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2026.02.26 № С 7А/26-23
танай _____ -ны № _____ -т

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Дүгнэлт

Бид “Аксис Капитал ББСБ” ХХК (цаашид “Компани”гэх)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (цаашид “СТОУС”гэх)-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн *Санхүүгийн Тайлангийн Аудиторын Үүрэг Хариуцлага* гэсэн хэсэгт тусгасан.

Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан *Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм* (цаашид “НБЭЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа мөрдөж ажилласан болно. Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

Санхүүгийн тайланд Удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээдэг. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын алдаа, санаатай зальт үйлдлээс үүсэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулахын тулд дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Компанийн удирдлага санхүүгийн тайланг бэлтгэхдээ компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд, тасралтгүй явуулах чадамжийг үнэлэх, тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу тайлангууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нэгдсэн дүнгээрээ уг санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилласан.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн “Аксис Капитал ББСБ” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2026 оны 2 сарын 26



Д.АЛТАНЦЭЦЭГ
Захирал, ММНБ

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тод	/ төгрөгөөр/	
		2024.12.31	Аудитлагдсан 2025.12.31
Хөрөнгө			
Мөнгөн хөрөнгө	3	764,171,928.14	2,229,795,326.31
Зээл /Цэврээр/	4	17,334,913,363.67	30,372,781,858.77
Бусад санхүүгийн хөрөнгө	5	275,820,656.45	
<u>Санхүүгийн хөрөнгийн дүн</u>		<u>18,374,905,948.26</u>	<u>32,602,577,185.08</u>
Үндсэн хөрөнгө	6	184,061,489.49	353,180,944.49
Биет бус хөрөнгө	7	22,958,156.80	35,308,076.26
Бусад санхүүгийн бус хөрөнгө		10,267,800.00	113,488,703.04
<u>Санхүүгийн бус хөрөнгийн дүн</u>		<u>217,287,446.29</u>	<u>501,977,723.79</u>
<u>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</u>		<u>18,592,193,394.55</u>	<u>33,104,554,908.87</u>
Өр төлбөр			
Итгэлцлийн үйлчилгээний эх үүсвэр			8,521,422,815.18
Банк, санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр		6,556,219,178.11	
Бусад эх үүсвэр			4,843,704,109.58
Бусад санхүүгийн өр төлбөр			
<u>Санхүүгийн өр төлбөрийн дүн</u>		<u>6,556,219,178.11</u>	<u>13,365,126,924.76</u>
Татвар,НДШ-ийн өр төлбөр		211,246,011.27	299,271,212.53
Бусад санхүүгийн бус өр төлбөр			13,236,332.98
<u>Санхүүгийн бус өр төлбөрийн дүн</u>		<u>211,246,011.27</u>	<u>312,507,545.51</u>
<u>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</u>		<u>6,767,465,189.38</u>	<u>13,677,634,470.27</u>
Өмч			
Хувь нийлүүлсэн хөрөнгө	8	10,000,000,000.00	13,000,000,000.00
Өмчийн бусад хэсэг			150,000,000.00
Хуримтлагдсан ашиг		1,824,728,205.17	6,276,920,438.60
<u>НИЙТ ӨМЧИЙН ДҮН</u>		<u>11,824,728,205.17</u>	<u>19,426,920,438.60</u>
<u>НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</u>		<u>18,592,193,394.55</u>	<u>33,104,554,908.87</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Тод	2024.12.31	2025.12.31
ХҮҮГИЙН ОРЛОГО			
Банканд байршуулсан хөрөнгийн		18,389,682.13	1,887,335.25
Зээлийн		2,602,410,489.31	8,791,249,893.98
Бусад		1,937,265.81	29,305,252.92
Хүүгийн орлогын буцаалт		-	-183,974,542.45
<u>Хүүгийн орлогын дүн</u>		<u>2,622,737,437.25</u>	<u>8,638,467,939.70</u>
Хүүгийн зардал			373,678,447.29
Итгэлцлийн үр шим			373,678,447.29
Зээлийн		405,712,329.07	1,155,232,419.43
Үнэт цаасны			630,958,904.10
Бусад			
<u>Хүүгийн зардлын дүн</u>		<u>405,712,329.07</u>	<u>2,159,869,770.82</u>
<u>Хүүгийн цэвэр орлого</u>		<u>2,217,025,108.18</u>	<u>6,478,598,168.88</u>
Эрсдэлийн сангийн зардал	9		251,193,500.82
<u>Эрсдэлийн сангийн дараах цэвэр орлого</u>		<u>2,217,025,108.18</u>	<u>6,227,404,668.06</u>
Бусад орлого	10	183,727,945.00	273,941,246.84
Бусад зардал	11	370,859,445.44	1,426,594,825.12
<u>ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ, АЛЛАГДАЛ</u>		<u>2,029,893,607.74</u>	<u>5,074,751,089.78</u>
Орлогын татварын зардал		205,165,402.57	472,558,856.35
<u>ТАТВАРЫН ДАРААХ АШИГ, АЛЛАГДАЛ</u>		<u>1,824,728,205.17</u>	<u>4,602,192,233.43</u>
<u>ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ, АЛЛАГДАЛ</u>		<u>1,824,728,205.17</u>	<u>4,602,192,233.43</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Бусад өөрийн хөрөнгө	Хуримтлагдсан Ашиг/алдагдал/	Нийт дүн
<u>2024 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</u>	<u>10,000,000,000.00</u>		<u>1,824,728,205.17</u>	<u>11,824,728,205.17</u>
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			-150,000,000.00	-150,000,000.00
Залруулсан үлдэгдэл	<u>10,000,000,000.00</u>		<u>1,674,728,205.17</u>	<u>11,674,728,205.17</u>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			4,602,192,233.43	4,602,192,233.43
Хуваарилсан ногдол ашиг				
Өмчид гарсан өөрчлөлт	3,000,000,000.00	150,000,000.00		3,150,000,000.00
<u>2025 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</u>	<u>13,000,000,000.00</u>	<u>150,000,000.00</u>	<u>6,276,920,438.60</u>	<u>19,426,920,438.60</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	2024.12.31	2025.12.31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Зээл, хүүгийн төлбөрт хүлээн авсан	2,272,473,035.21	8,822,442,482.15
Итгэлцлийн үйлчилгээнээс хүлээн авсан	-	8,359,193,973.60
Бусад	13,573,622,422.25	8,284,224,753.79
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	<u>15,846,095,457.46</u>	<u>25,465,861,209.54</u>
Олгосон зээл	17,334,913,363.67	30,133,633,555.63
Ажиллагсадад олгосон	143,813,477.61	636,589,947.49
Татвар,НДШ-ийн байгууллагад төлсөн	51,510,527.88	149,726,168.83
Ашиглалтын зардалд төлсөн	11,538,208.00	9,351,480.00
Бусад	7,345,368,237.16	550,419,255.55
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	<u>24,887,143,814.32</u>	<u>31,479,720,407.50</u>
<u>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	<u>-9,041,048,356.86</u>	<u>-6,013,859,197.96</u>
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө оруулалтаас хүлээн авсан	10,000,000,000.00	3,000,000,000.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	<u>10,000,000,000.00</u>	<u>3,000,000,000.00</u>
Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө олж эзэмшихэд төл	194,799,715.00	225,855,135.75
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн зарлага	<u>194,799,715.00</u>	<u>225,855,135.75</u>
<u>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>	<u>9,805,200,285.00</u>	<u>2,774,144,864.25</u>
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлээс хүлээн авсан		5,500,000,000.00
Бусад		4,700,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн орлого		<u>10,200,000,000.00</u>
Банк, санхүүгийн байгууллага, төсөл, хөтөлбөрийн зээлд төлсөн		5,500,000,000.00
Бусад		<u>5,500,000,000.00</u>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн зарлага		<u>5,500,000,000.00</u>
<u>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</u>		<u>4,700,000,000.00</u>
Валютын ханшийн зөрүү		5,337,731.88
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	764,151,928.14	1,465,623,398.17
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</u>	<u>20,000.00</u>	<u>764,171,928.14</u>
<u>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</u>	<u>764,171,928.14</u>	<u>2,229,795,326.31</u>

Нэмэлт тодруулга нь санхүүгийн тайлангийн нэг салшгүй хэсэг болно.